



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/5502

Номгон

“Зооноз өвчин судлалын төвийн гадна бохир”
усны шугам сүлжээний” ажлыг эрх шилжүүлэн
гүйцэтгүүлэх тухай


Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2. “а” дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зооноз өвчин судлалын төвийн гадна бохир усны шугам сүлжээний” 9,752,270 (Есөн сая долоон зуун тавин хоёр мянга хоёр зуун далан) төгрөгийн ажлыг Зооноз өвчин судлалын төвд эрх шилжүүлж гүйцэтгүүлсүгэй.

2. Эрх шилжсэнтэй холбогдуулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу 09 дүгээр сарын 15-ны дотор зохион байгуулж, явцын ажилд хяналт тавьж ажиллахыг Зооноз өвчин судлалын төвийн дарга (С.Баасанхүү)-д үүрэг болгосугай.

3. Дээрх 9,752,270 (Есөн сая долоон зуун тавин хоёр мянга хоёр зуун далан) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4. “Зооноз өвчин судлалын төвийн гадна бохир усны шугам сүлжээний” ажилд хяналт тавьж цаг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж хүлээн авч ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

601210281